

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-04-01

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 04 дүгээр сарын 08-ны “Мягмар” гарат** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн ил тод, шуурхай зохион байгуулан, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй томоохон ажлуудын гүйцэтгэлийг энэ 7 хоногт багтаан эхлүүлэх;	СТСХ, ХААА, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд
2	Улс, нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, цахим худалдаанаас татвар авах ажлыг зохион байгуулах;	Татварын хэлтэс
3	Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлуудаа эрчимжүүлэн, дүүргийн төсөвт хийгдэх тодотголын бэлтгэлийг хангах;	СТСХ, ХААА
4	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж гарах “Паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам” болон “Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, түүнийг төлөх журам”-ын төслийг боловсруулж, холбогдох яамдад хүргүүлэх чиглэл өгөгдсөний дагуу холбогдох байгууллагаас тодруулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллах.	БҮТП ХК
5	Дүүргийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлуудын газар чөлөөлөлтийг эрчимжүүлж, хэрэгжилтийг тогтмол	ГЗБА

	танилцуулж ажиллах;	
6	Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулж, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалах, зэрэг ажлуудаа эрчимжүүлэх;	НХХ, Соёлын ордон
7	Нохой, муур барих ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нэгдсэн байдлаар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах;	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Хороод
8	Нийслэлийн хэмжээнд ой, хээрийн түймэр, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлуудыг шуурхай зохион байгуулах;	ОБХ
9	Нийслэлийн хэмжээнд хороодын Засаг дарга нартай 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр уулзалт зохион байгуулах тул бэлтгэлийг ханган оролцох;	ТЗУХ, Хороод
10	Камерын нэгдсэн систем ашиглалтад орохтой холбогдуулан цаашид зөрчилтэй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх, журамлах ажлын талаар олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах;	ЦХ-ийн Замын цагдаагийн хэсэг, Багахангай Теле хяналтын камерын дэд төв ОНӨТҮГ
11	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ хүүхэд, залуучууд, ахмадуудыг чөлөөтэй амрах талбайг бий болгож, халуун сүү худалддаг болох;	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
12	Нийслэлээс дүүрэгт ажиллуулах байцаагчдыг дүүрэг, орон нутагт ажиллуулах бэлтгэл ажлыг хангах;	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц
13	Нийслэлийн Засаг даргын А/237 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүрэгт байгуулагдсан Ажлын хэсгийн зүгээс холбогдох шалгалтыг хийж илрүүлсэн зөрчлүүдийг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
14	Гадаадын хамтын ажиллагааны хүрээнд зочид төлөөлөгчид 04 дүгээр сарын 09-ний өдөр дүүрэгт ирж ажиллахтай холбогдуулан бэлтгэлийг сайтар хангах;	ЗДТГ
15	Хороодод үйл ажиллагаа явуулж буй ТҮЦ-үүдийн байршлыг өөрчлөн, үйл ажиллагааг эрхлэн явуулах чиглэл өгч ажиллах;	ТХҮХ
16	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй эргүүлийн үйл ажиллагаанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Дүүргийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР